

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2022 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАВСРАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 11 дүгээр сарын 20

Мандалговь хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
		Зарцуулсан хөрөнгө сая.төгрөг	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар /
НЭГ. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ " ГЭРЭЭНИЙ ЗААЛТЫН ХҮРЭЭНД					
1.1.	Сургуулийн өмнөх боловсролд малчин өрхийн хүүхдүүдийг хамруулах	-	Малчин өрхийн хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт	1162 хүүхэд	Малчин өрхийн 1172 хүүхэд ердийн болон хувилбарт сургалтад хамрагдаж, хамралт 100 хувьтай байна. Хэрэгжилт 100 хувь
1.2	Сургуулийн өмнөх боловсролд Эмзэг бүлгийн өрхийн хүүхдийг хамруулах	-	Эмзэг бүлгийн өрхийн хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт	74 хүүхэд	Аймгийн 22 цэцэрлэгт амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой болон хагас ба бүтэн өнчин 100 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамрууллаа. Хэрэгжилт 100 хувь
1.3	Сургуулийн өмнөх боловсролд тусгай хэрэгцээт хүүхдийг хамруулах	-	Тусгай хэрэгцээт хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт	22 хүүхэд	2022 оны эцсийн байдлаар тусгай хэрэгцээт боловсролд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй 22 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамрууллаа. Хүнд хэлбэрийн 5 хүүхэд цэцэрлэгт тогтмол явах болможгүй тул зайны сургалтаар явж байна. Сайнцагаан сумын Улсын тэргүүний 3-р цэцэрлэг “Тэгш хамруулах” төсөлд хамрагдаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулах орчин нөхцөл, хүний нөөцийг чадавхжуулах сургалтад үе шаттай хамрагдаж, аймгийн

					хэмжээний загвар цэцэрлэг болохоор ажиллаж байна. Хэрэгжилт 100 хувь
1.4	Сургуулийн өмнөх боловсролд Үндэсний цөөнхийн хүүхдийг хамруулах	-	Үндэсний цөөнхийн хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт*	-	Байхгүй
1.5	Цэцэрлэгт орон нутгийн төсвийн хөрөнгө, иргэд, байгууллагын хандив, тусламжаар сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом нийлүүлэх	ОНТ Хандив 153,1 сая	Цэцэрлэгт орон нутгийн төсвийн хөрөнгө, иргэд, байгууллагын хандив, тусламжаар нийлүүлсэн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн төрөл, зардлын хэмжээ	Орон нутгийн төсвийн зарлагын 5- хүртэлх хувь	Жилийн эцсийн байдлаар 22 цэцэрлэгт иргэд, аж ахуйн нэгжийн тусламжаар 68.7 сая төгрөг, Луус, Гурвансайхан, Өндөршил, Эрдэнэдалай, Адаацаг сумдын цэцэрлэгүүдэд Орон нутгийн хөгжлийн сангаас 80.3 сая төгрөг, Сайнцагаан сумын 3-р цэцэрлэгийн хөл бөмбөгийн талбайд 4.0 сая төгрөгний төсөл тус тус дэмжигдэж нийт 153.1 сая төгрөгний 53 нэр төрлийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом, тоног төхөөрөмж нийлүүлсэн нь салбарын орон нутгийн нийт төсвийн зарлагын 2,55 хувьтай тэнцүү хэмжээтэй зарцуулсан байна. Хэрэгжилт ...

1.6.	Багш ажилтныг мэргэжлийн тасралтгүй хөгжлийн арга хэмжээнд хамруулах	улсын төсөв 20.0	Мэргэжлийн тасралтгүй хөгжлийн арга хэмжээнд хамрагдсан багш, ажилтны эзлэх хувь	Тухайн орон нутгийн нийт багш нарын 60-аас доошгүй хувь	Багшийн хөгжлийн зардал СӨББайгууллагад 20.7 сая төгрөг батлагдан Аймгийн хэмжээний сургуулийн өмнөх боловсролын салбарын багш ажилчдад цахим болон танхимын сургалтыг зохион байгуулж нийт 147 удаагийн арга хэмжээгээр давхардсан тоогоор 1760 багш ажилчид хамрагдсан байна. Энэ нь багш бүр ажлын байран дээрээ тасралтгүй хөгжиж мэргэжил арга зүйгээ дээшлүүлсэн үр дүнд хүрсэн байна. БЕГ-аас зохион байгуулж байгаа Багшийн хөгжлийг дэмжих сонголтот болон зорилтот сургалтад аймгийн хэмжээний 22 цэцэрлэгийн 112 багш онлайнаар 100 хувь суралцаж ажлын байрандаа хөгжиж байгаа нь орон нутгийн нийт багш нарын 60-аас дээш хувийг хамруулсан байна. Хэрэгжилт 100 хувь
ХОЁР.ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ					
2.1	Ерөнхий боловсролд тусгай хэрэгцээт суралцагчдийг тэгш хамруулах ажлыг зохион байгуулах		Тусгай хэрэгцээт суралцагчийн хамрагдалт	2021-2022 оны хичээлийн жилд хамрагдсан сурагчийн тоог 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх	2022-2023 оны хичээлийн жилд тэгш хамран сургах, тусгай бүлгээр хичээллэхээс татгалзах бодлогын хүрээнд ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй 78 хүүхэд ердийн болон насан туршийн боловсролын үйлчилгээнд хамрагдлаа. Нийт хамрагдвал зохих 114 хүүхдээс 78 нь хамрагдаж өмнөх оныхоос 57-н хүүхдээр нэмэгдэж 68.4 хувьд хүрсэн нь 44.9 хувиар нэмэгдсэн байна. Хэрэгжилт 100 хувь
2.2	ЕБС-ийн V ангийн математик, монгол хэлний хичээлийн сургалтын чанарыг сайжруулах		V ангийн математик, монгол хэлний хичээлийн сургалтын	Математик - 51.0 Монгол хэл -48.1	5 дугаар ангийн монгол хэлний хичээлийн аймгийн дундаж 75.6 хувь, математикийн хичээл 64.77 хувьтай шалгагдсан байна. Хэрэгжилт 100 хувь

			амжилтын дундаж		
2.3	ЕБС-д орон нутгийн төсвийн хөрөнгө, иргэд, байгууллагын хандив, тусламжаар сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлэх, анги танхим байгуулах	Орон нутгийн төсөв, хандив 528.6	ЕБС-д орон нутгийн төсвийн хөрөнгө, иргэд, байгууллагын хандив, тусламжаар нийлүүлсэн сургалтын хэрэглэгдэхүүний төрөл, зардлын хэмжээ	-	2022 онд аймгийн ерөнхий боловсролын 9 сургууль хими, биологи, физик, багын байгалийн ухааны 11 кабинетыг шинээр байгуулж, байгалийн ухааны хичээлийн сургалтын чанарыг ахиулах материаллаг баазыг бүрдүүлэхэд 23,9 сая төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна. Биеийн тамирын сургалтын орчныг сайжруулах, сурагчдын танин мэдэхүйд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Олимп танхим”-ыг шинээр 6 сургууль байгуулан 10,7 сая төгрөгийг иргэдийн хандив болон улсын төсвөөр шийдвэрлэлээ. Орчны тохижилтод орон нутгийн хөгжлийн сан, эцэг эх, иргэдийн хандиваар цэцэрлэгт 180 сая төгрөг, сургуульд 314 сая төгрөгийн тохижилт хийжээ. Хэрэгжилт 100 хувь
2.4	Багш, ажилтныг мэргэжлийн тасралтгүй хөгжлийн арга хэмжээнд хамруулах	улсын төсөв 116,2	Багш ажилтны эзлэх хувь	О	Багшийн хөгжлийн зардал ЕБСургуульд 116.2 сая төгрөг батлагдан, мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад 134, орон нутгийн сургалтад 285 нийт - 419 багш ажилтнууд хамрагдсан байна. БШУГ-аас аймгийн хэмжээний 19 сургуулийн багш, удирдах ажилтан, номын санч, эмч, тогооч, нярав, нягтлан зэрэг албан хаагчдын мэдлэг, ур чадвар, аргазүйг дээшлүүлэхэд чиглэсэн нийт 43 удаагийн арга хэмжээг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж давхардсан тоогоор 3068 ажилтан, албан хаагч багш нарыг хамруулсан. Мөн БЕГ-аас зохион байгуулж байгаа Багшийн хөгжлийг дэмжих сонголтот болон зорилтот сургалтад аймгийн хэмжээний ЕБС-ийн 521 багш онлайнаар суралцаж ажлын байрандаа суралцан хөгжиж байна. Хэрэгжилт 100 хувь

2.5	Сайнцагаан сумын Мандал, Хүмүүнлэг сургуулийн сурагчдыг автобусаар үйлчилсэн байх		Сургуулийн автобусаар үйлчлүүлсэн сурагчийн тоо	Тухайн орон нутгийн нийт багш нарын 60-аас доошгүй хувь	Сайнцагаан сумын Хүмүүнлэг, Мандал сургуулийн нийт 1637 хүүхдийн 989 хүүхэд буюу 60.4 хувь нь автобусаар үйлчлүүлсэн байна. Гэвч 2 сургуулийн автобус сэлбэг хэрэгсэл олдохгүй, мөн сургуулиудын автомашиныг хураахтай холбогдуулан сурагчид олимпиад уралдаан тэмцээн явах, багш нар сургалтад хамрагдах зэрэг маш их хүндрэл бэрхшээл үүсэн болно. /энэ хүндэрлийг даван туулахын тулд аймаг болон орон нутгийн хөгжлийн сангаас сургуулиудыг машинтай болгох ажил сүүлийн 5 жилд хийгдсэн болно/ Хэрэгжилт 100 хувь
2.6	Их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авах монгол хэл, бичгийн шалгалтад суралцагчдыг бүрэн хамруулж, сурлагын амжилтыг ахиулах		Их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авах монгол хэл, бичгийн шалгалтад суралцагчдыг бүрэн хамруулж, сурлагын амжилтыг ахиулах	Аймгийн хэмжээст онооны дунджийг 547 - д хүргэх	Аймгийн Монгол хэл, бичгийн 2022 оны хэмжээст онооны дундаж 551-тэй шалгагдсан байна. Хэрэгжилт 100 хувь
2.7	Их, дээд сургууль, коллежид элсэгчдээс авах элсэлтийн ерөнхий шалгалтыг чанартай зохион байгуулах, сурлагын амжилтыг ахиулах		Хэмжээст оноо	Аймгийн хэмжээст онооны дунджийг 521- д хүргэх	Элсэлтийн ерөнхий шалгалтын 2022 оны хэмжээст онооны дундаж 509.59 байгаа нь өмнөх оныхоос 19.46 оноогоор буурсан үзүүлэлттэй. Улсын дунджаас өндөр оноотой шалгагдсан монгол хэл, физик, газарзүй, түүхийн хичээлүүд байна. Улсын дунджид хүрээгүй математик-1,67 оноогоор доогуур өмнөх оныхоос 3,66 оноогоор буурсан, нийгэм-5,7 оноогоор доогуур, өмнөх оныхоос 1,77 оноогоор өссөн, англи хэл улсын дунджаас 30.79 оноогоор доогуур, орос хэл-221,03 оноогоор доогуур өнгөрсөн оныхоос 190,25 оноогоор доогуур, биологи-14,05 оноогоор доогуур, өнгөрсөн оныхоос 3,28 оноогоор өссөн, хими-21,25 оноогоор доогуур, өнгөрсөн

					оныхоос 1,23 оноогоор буурсан үзүүлэлттэй тус тус шалгагдсан нь өмнөх оны амжилт буурах гол шалтгаан нөхцөл болсон. Хэрэгжилт 97.80 хувь
ГУРАВ.СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ					
3.1	Сургуулийн хоолны газарт засвар үйлчилгээ , өргөтгөл хийх	Улсын төсөв 9.7	Сургуулийн тоо	9 сургууль	Дэлгэрцогт, Өндөршил сумын сургуулийн үдийн хоол үйлдвэрлэлийн хэсгийн цахилгааны шугамыг янзалж автоматыг шинэчилсэн байна. Адаацаг сумын сургуулийн үдийн хоол үйлдвэрлэлийн хэсэг нь таазаа лампердаж, ханаа эмульдэж завсар үйлчилгээг хийсэн. Эрдэнэдалай сумын дотуур байрны хоол үйлдвэрлэлийн хэсгийн дээвэрт 1,000,000 төгрөгний засвар хийсэн. Өлзийт сумын дотуур байрны хоолны зааланд 1.500.000 төгрөгний таазны лампир болон 2.300.000 төгрөгний уур сорогчийг шинээр тавьж хэвийн ажиллагаанд орууллаа. Гурвансайхан сумын сургуулийн үдийн хоолны хэсгийн халаалтын шугам задарсан тул пильта болон турбаг солиход 221.000 төгрөгийг зарцуулсан. Дэрэнгийн сургуулийн дотуур байрны гал тогооны дотор хананд 4,686,400 төгрөгний засвар хийлээ. Жилийн эцсийн байдлаар 4 сургуулийн үдийн хоол үйлдвэрлэлийн хэсгийн цахилгааны шугамыг янзалж, хана, таазандаа засвар үйлчилгээ хийлээ. 3 сургуулийн дотуур байрын гал тогооны хэсэгт засвар үйлчилгээг хийсэн байна. Хэрэгжилт 77 хувь

3.2	Сургуулийн хоолны газрын тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх	УТ 90.9 сая ОНТ Иргэдийн хандив, тусламж 0.8	Сургуулийн хоолны газрын тоног төхөөрөмж	13 сургууль	Адаацаг сумын сургуулийн гал тогоонд 10 нэр төрлийн тоног төхөөрөмж, Говь-Угтаал сумын сургуулийн гал тогоонд 9 төрлийн тоног төхөөрөмжийг Улсын төсвийн 6480000 төгрөгийн зардлаар 2 тоног төхөөрөмжийг 800000 төгрөгийн хандиваар авсан. Өлзийт сумын дотуур байрын гал тогооны плитканы ширэмний тенийг сольж, уурын жигнүүрийг шинэчилсэн. БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар Эрдмийн далай цогцолбор сургуулийн гал тогоонд 30,766,000 төгрөг, Хүмүүнлэг сургуулийн гал тогоонд 10,165,00 төгрөг, Эрдэнэдалай сумын сургуулийн гал тогоонд 40,000,000 төгрөг, ГИЦС-н Дотуур байрны гал тогоонд 10.165.000 төгрөгний 1,2-р хоолны тогоо, дээжний хөргөгч, ариутгагч, хөргөгч зэрэг тоног төхөөрөмжөөр хангагдлаа. Мандал сургуулийн гал тогоонд 1,979,500 төгрөгний үнэ бүхий ногоо цэвэрлэгч төхөөрөмжийг худалдан авлаа. Говийн-Ирээдүй, Мандал сургуулийн гал тогоонд Жайкагийн Үдийн хоол үйлдвэрлэлийн төслийн хүрээнд тоног төхөөрөмжүүд нийлүүлээд байна. Дунд анги үдийн хоолтой болохтой холбогдуулан аймгийн хэмжээнд үдийн хоолны тоног төхөөрөмжид анхаарч улсын төсвийн хөрөнгө оруулалтад гал тогооны тоног төхөөрөмж авахаар техникийн шаардлагыг боловсруулан Яаманд саналаа хүргүүлсний үндсэн дээр 500 орчим сая төгрөгөнд тоног төхөөрөмж нийлүүлэхээр хүлээгдэж байна. / хил хаасантай холбогдуулан/ Хэрэгжилт 100 хувь
3.3	Үдийн хоолны үйлчилгээг тухайн сургууль өөрөө зохион байгуулах	-	Үдийн хоолны үйлчилгээг сургууль өөрөө	Бүх сургуульд 5 өдөр халуун хоол	Ерөнхий боловсролын 19 сургууль бага ангийн үдийн хоол үйлдвэрлэлийг өөрөө 100 хувь хариуцан хэрэгжүүлж байгаа бөгөөд 4 өдөр махан хоол, нэг өдөр цагаан хоолоор үйлчилж, хоол үйлдвэрлэлийн

			хэрэгжүүлдэг болох		цахим системийг 88 хувь нь бүрэн ашиглаж үйл ажиллагаагаа явуулж байна. Хэрэгжилт 100 хувь
3.4	Ерөнхий боловсролын сургуулиудыг ус цэвэршүүлэгч тоног төхөөрөмжөөр хангах	Улсын төсөв, хандив 10.0	Ус цэвэршүүлэгч тоног төхөөрөмжөөр хангах /75 хүүхдэд 1 төхөөрөмж байхаар тооцох/	Бүх сургуульд	19 сургуулиас 16 сургуулийн сурагчид, сургуулийн орчинд цэвэршүүлсэн ус уух боломжоор бүрэн хангагдсан буюу 72 хүүхдэд 1 ус цэвэршүүлэгч төхөөрөмж ногдож байна. Мөн сургуулийн үдийн хоол үйлдвэрлэлийн хэсгийн ундны усанд 7 сургууль ус цэвэршүүлэгч байрлуулсан байна. Аймгийн хэмжээгээр ангид болон нийтийн эзэмшлийн газарт 120 ширхэг ус шүүгч тавьж ашиглаж байна. Хэрэгжилт 84. 2 хувь
ДӨРӨВ. НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ					
4.1	Иргэдийг насан туршийн суралцахуй, нөлөөллийн үйл ажиллагаанд хамруулах		Насан туршийн суралцахуйн үйл ажиллагаанд хамрагдсан иргэний тоо	58064	Аймгийн хэмжээнд 2022 оны жилийн эцэст 15 нэгжийн 15 багш 9 чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулж, 667 сургалтаар 33523 суралцагчдад, нөлөөллийн 742 үйл ажиллагаанд 25922 иргэн оролцож нийт-59445 хүнд насан туршдаа суралцахуйн үйлчилгээ үзүүлсэн нь тэднийг мэдээллээр хангасан, насан туршийн суралцахуйг дэмжсэн арга хэмжээ болов. Хэрэгжилт 100 хувь
4.2	Ерөнхий боловсролыг нөхөн олгох ажлыг зохион байгуулах		Ерөнхий боловсрол нөхөн эзэмшсэн иргэний тоо	66	ЕБС-ийн 2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилд боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн сургалтад нийт 69 сурагч, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 34 иргэн, хүнд болон хэвтрийн 5 иргэн боловсрол нөхөн олгох хөтөлбөрт хамрагдсан нь зорилтот бүлгийн хүүхэд иргэдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулсан үр дүнтэй ажил болов. Бага боловсролд 20 сурагч, суурь боловсролд 36 сурагч, БДБ-д 13 сурагч тус тус

					суралцан, бага, суурь, бүрэн дундын боловсролыг эзмшлээ. Хэрэгжилт 100 хувь
4.3	Бичиг, үсэггүй залуучуудыг бичиг үсгийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах		Бичиг үсгийн сургалтад хамрагдсан бичиг үсэггүй залуучуудын тоо	10	Аймгийн 14 сумын Насан туршийн боловсролын нэгжийн багш нар 68 багийн Засаг дарга нартай хамтран ажиллан, бичиг үсэггүй иргэдийг судалгаагаар илрүүлж, 19 иргэний 63 хувь буюу 12 иргэнийг бичиг үсгийн сургалтад хамруулан бичиг үсэгт тайлсан нь өмнөх оны мөн үеийнхээс бичиг үсэггүй иргэдийн тоо 2-оор буурсан үзүүлэлттэй байна. Хэрэгжилт 100 хувь
ТАВ.НИЙТЛЭГ					
5.1	Боловсролын байгууллагын багш, ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах	Улсын төсөв 79.8	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан боловсролын байгууллагын багш, ажилтны эзлэх хувь	Багш, ажилтны 30-аас доошгүй хувь	Боловсролын салбарын багш, ажилчдын эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгооны зардалд 79.8 сая төгрөг батлагдснаас 90 орчим хувийг зарцууллаа. 19 сургуулийн нийт 961 багш, ажилтнаас 625 буюу 65% нь хамрагдсан байна. 22 цэцэрлэгийн нийт 524 багш, ажилтнаас 375 буюу 71% нь хамрагдсан. Багшийн эрүүл мэндийг дэмжих чиглэлийн хүрээнд Багшийн нэмэлт үзлэгийн багц үзлэг нярав, тогооч нарын урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд 19 сургуулийн 625 багш, ажилтан, 22 цэцэрлэгийн 375 багш, ажилтан хамрагдсан. Хэрэгжилт 100 хувь
5.2	Боловсролын байгууллагын багш, ажилтанд нутгийн	Орон нутгийн	Боловсролын байгууллагын багш, ажилтанд	Орон нутгийн төсвийн	2022 оны жилийн эцсээр нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас 48 арга хэмжээний хүрээнд 19

	захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас урамшуулал олгож, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	төсөв, хандив	урамшуулал олгох, нийгмийн баталгааг сайжруулахад нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас үзүүлсэн дэмжлэг арга хэмжээний тоо, хамрагдсан багш ажилтны тоо, зардлын хэмжээ	зарлагын 10 хүртэлх хувь	сургуулийн 402 багшид тэдний нийгмийн баталгааг сайжруулахад зориулж 128 сая төгрөгийн уламшууллыг олгожээ.Цэцэрлэгт 28,4 сая төгрөг, аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд магистрт суралцаж буй 100 багшийн сургалтын төлбөрийн дэмжлэг 50 сая, орон сууцны дэмжлэг 1 багшид 10.0, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан 80 хүүхдэд төлбөрийн дэмжлэг 40,0 сая, TOFEL сургалт, шалгалтын төв нээх багшийн сургалтын төлбөр 600.0, шилдэг багш 12.0 сая төгрөг зарцуулсан байна. Багш нарын нийгмийн баталгааг сайжруулахад 269.2 сая төгрөгийг зарцуулсан нь орон нутгийн боловсролын салбарын төсвийн зарлагын 1,6 хувийг эзэлж байна. Хэрэгжилт 90 хувь
5.3	Ээлжит хичээлийн цахим контентыг цахимд байршуулах		Ахлах ангийн ээлжит хичээлийн цахим контентын тоо	227	Мэдлэ.мн платформд аймгийн 19 сургуулийн 29 багш бие даан болон багаараа 16 нэгжийн 122 цагийн ээлжит хичээлийн цахим контентийг болдовсруулан байршуулж, 38 багш багаар хамтран 14 нэгжийн 120 цагийн ээлжит хичээлийг боловсруулах эрх авсан нь багш нарын багаар, мэргэжлийн хөгжлийн бүлгээр хамтран ажиллах чадварт суралцаж байгаагийн үр дүн юм. Хэрэгжилт 53,7 хувь
5.4	Боловсролын байгууллагын ажиллагчдын боловсролын баримт бичгийг мэдээллийн системд оруулах		Боловсролын байгууллагад ажиллагчдын боловсролын баримт бичгийг мэдээллийн системд оруулан	100 хувь	БШУЯ-нд аймгийн боловсролын салбарын удирдах болон мэргэжлийн багш нарын дипломын хуулбарыг нэгтгэн 100 хувь хүргүүлсэн. Архивын ерөнхий газрын лавлагаа, багш ажилтнуудын өргөдөл, дипломын хуулбарыг 100 хувь БЕГ-т хүргэж, Мэдээллийн систем оруулах ажил хийгдсэнээр, хуурамч бичиг баримтыг шалгах ажил хийгдэж байна.

			лавлагаа үүсгэсэн байна		Хэрэгжилт 100 хувь
5.5	Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр, сурагчийн дотуур байруудыг интернэтэд холбох		Интернэтэд холбогдсон сургууль, хичээлийн байр, дотуур байрны тоо	100 хувь	19 сургуулийн 27 хичээлийн байр 100 хувь шилэн кабелийн өндөр хурдны интернэтэд холбогдсон. Сургуулийн бүх багш нарт unitel-ийн сар бүрийн дата олгож байна. Сургуулийн дотуур байранд гэр интернэтийн төхөөрөмж болон шилэн кабелийн интернэт холболтоор 8 дотуур байр буюу 50 хувь холболт хийгдсэн. Хичээлийн байр, дотуур байрны 43 байрны 81,3 хувь нь интернэт ашиглаж байна. Хэрэгжилт 81,3 хувь
Гүйцэтгэлийн дундаж хувь		25 үзүүлэлтээс 1 хамаарахгүй, 24 үзүүлэлт		ДУНДАЖ 2234 / 24= 93.08 хувь	

ГЭРЭЭНИЙ ХОЁРДУГААР ХАВСРАЛТ

НЭГ. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ЭРХ ШИЛЖҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/430 тоот тушаалаар эрх шилжүүлсэн.

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг /сая.төг/	Тухайн онд санхүүжи х дүн /сая.төг/
			Эхлэх	Дууса Х		

1	XIII.1.1.326	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Сайнцагаан сум, 2 дугаар цэцэрлэг/	2022	2023	3,026.0	Дундговь, Сайнцагаан сум, 2 дугаар цэцэрлэгийн барилгын буулгалтын ажил хийгдэж дууссан байна. Барилгын ажил эхлээгүй. 2022 онд 239.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тавигдаад байна.
2	XIII.1.3.5	"Их соёл - Эх үндэс" төсөл хөтөлбөр /Дундговь, Говьсүмбэр/	2022	2022	1,000.0	1,000.0 хөрөнгө оруулалт 100 хувь хийгдсэн байна.

—oOo—

ХОЁР. ДУНДГОВЬ АЙМАГТ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТҮЛХҮҮР ГАРДУУЛАХ ГЭРЭЭНИЙ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ, ДОТУУР БАЙРНЫ НҮХЭН ЖОРЛОНГ АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР СОЛИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

Сум	Төрөл	Батлагдсан төсөв /сая.төг/	Гэрээний дүн /сая .төг/	Гүйцэтгэгчийн нэр
1-р ээлж				
Дэлгэрхангай	Сургууль-2, Дотуур байр-1	1,100.00	1,050.00	"Винтер гарден" ХХ К 88119027
Эрдэнэдалай	Сургууль-2, Дотуур 5айр-1			Цагаандэлгэр, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумын сургуулийн 00 шинээр барих, сайжруулах ажлын гүйцэтгэл 100 хувь ашиглалтад ороод байна.
2-р ээлж				

Цагаандэлгэр	Сургууль-1, Дотуур байр-1	Цэцэрлэг-1,	1,075.00	968.50	Цагаандэлгэр, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумын сургуулийн 00 шинээр барих, сайжруулах ажлын гүйцэтгэл 100 хувь ашиглалтад ороод байна.
--------------	------------------------------	-------------	----------	--------	---

БАТАЛГААЖУУЛСАН: ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

ХШҮ ХИЙСЭН: ХШҮХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Э.ОДОНЧИМЭГ